

АРАБЫН ХОЙГИЙН ОРНУУДЫН ГАДААД БОДЛОГО, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ

Н.Билгүүн¹

Арабын ертөнцийг Ойрхи Дорнод)Дундад Дорнод, арабаар Аль-Шаркат аль-Авсат)-ын ба Хойд Африкийн орнууд, цаашилвал Левантын, Магрибын, Халижийн орнууд хэмээн газарзүйн байршлаар нь ангилан үзэж болно. 1902 онд АНУ-ын тэнгисийн цэргийн онолч Алфред Тайер Махан Лондоны “Нэйшнл Рэвью” сэтгүүлд “Персийн булан ба олон улсын харилцаа” өгүүлэл нийтлүүлэхдээ Араб болон Энэтхэгийн хоорондох бүс нутгийг Дундад Дорнод хэмээн анх томъёолжээ. 1903 онд Их Британий дипломатч Игнатий Валентин Чирол Лондоны “Таймс” сонинд “Дундад Дорнодын асуудал” цуврал өгүүлэл нийтлүүлэхдээ Энэтхэгийн хил хүртэлх Азийн бүс нутгийг үүнд хамааруулсан байдаг. Дэлхийн хоёрдугаар дайнаас өмнө Месопотамиас Бирм хүртэлх бүс нутгийг Дундад Дорнод хэмээн нэрлэдэг байв. АНУ-ын Ерөнхийлөгч Дуайт Эйзенхауэр 1957 онд Конгресст хүргүүлсэн илгээлтдээ Дундад Дорнод нэр томъёог албан ёсоор анх удаа ашигласан. Улмаар Европ, АНУ-д Дундад Дорнод гэсэн нэр томъёо өргөнөөр ашиглагдах болсон юм. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жон Фостер Даллес Дундад Дорнодыг тодорхойлохдоо “баруун зүгт Ливи, зүүн зүгт Пакистан, хойд зүгт Сири, Иран, өмнө зүгт Арабын хойгоор хязгаарлагдах бөгөөд Судан, Эфиопийг багтаасан бүс нутаг” гэжээ. Оросууд Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш Middle East нэр томъёог Ближний Восток хэмээн хэрэглэх болжээ. Харин бидний хувьд орос хэлнээс шууд орчуулан Ойрхи Дорнод хэмээн ярьж, бичиж хэвшсэн билээ.

1. Олон улсын харилцааны магистр

*АРАБЫН ХОЙГИЙН ОРНУУДЫН ГАДААД БОДЛОГО,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ*

Ойрхи Дорнодын бүс нутагт хорь гаруй орон (Афганистан, АНЭУ, Бахрейн, Египет, Израиль, Ирак, Иран, Йемен, Йордан, Катар, Кувейт, Ливан, Оман, Пакистан, Палестин, Саудын Араб, Сири, Турк) оршдог агаад исламын шашин ноёрхож, араб, перс, турк үндэстнүүд зонхилохоос гадна газрын тос, байгалийн хийн дэлхийн нөөцийн 2/3-ыг эзэмшдэг. Чухам үүгээрээ тус бүс нутаг нь дэлхийн улс төр, эдийн засаг болоод геостратегийн чухал төв юм. Бид арабын орнуудаас арай илүү харилцаатай гэдгээрээ Персийн булангийн (эсвэл Булангийн) орнуудын талаар харьцангуй илүү мэдээлэлтэй байдаг. Эндээс Персийн булангийн орнууд, Булангийн орнуудын аль нь илүү оновчтой нэршил вэ гэдэг асуулт урган гарна. Хэрэв Персийн булангийн орнууд гэвэл АНЭУ, Бахрейн, Катар, Кувейт, Оман, Саудын Араб дээр Ирак, Иран нэмэгдэнэ. Арабууд Персийн буланг Арабын булан (арабаар Аль-Халиж аль-Араби) хэмээн нэрлэж, газрын зураг дээр албан ёсоор ийн тэмдэглэдэг. Араб хүнтэй, ялангуяа тус бүс нутгаас ирсэн хүнтэй яриа хэлэлцээ хийхдээ Персийн гэсэн үгийг дурдвал дургүйцэн хүлээн авна. АНЭУ, Бахрейн, Катар, Кувейт, Оман, Саудын Араб хамтран байгуулсан Булангийн орнуудын хамтын ажиллагааны зөвлөл гэх бүс нутгийн байгууллага бий. Гэхдээ Булангийн орнууд хэмээн ярьж бичвэл Иран үүнд хамаарна хэмээн мэтгэлцэх судлаачид цөөнгүй. Эсвэл олон улсын хэллэгээр Персийн булан гэх нь зүйтэй ч гэдэг. Тиймээс нэр дурдсан зургаан орныг нийтэд нь хамруулан ярьж бичихдээ тэдгээрийн газарзүйн байршлын дагуу Арабын хойгийн орнууд хэмээх нь оновчтой гэж үзсэн болно.

Саудын Арабын Хаант Улсыг (арабаар Аль-Мамлакат аль-Саудия аль-Арабия) Аль-Сауд овгийн тэргүүн буюу Хаан удирддаг бөгөөд Аль-Саудын удирдсан Хаант Улс гэсэн утгатай. Эрх баригч овгийн нэрээр нэрлэгдсэн дэлхий дээрх гурван улсын нэг. Арабын Нэгдсэн Эмирт Улс (арабаар Аль-Имарат аль-Арабият аль-Муттахида) нь Абу Даби, Ажман, Дубай, Рас аль-Хайма, Умм аль-Кайвайн, Фужейра, Шаржа гэсэн долоон Эмирт улсаас бүрдсэн холбооны улс бөгөөд Абу Дабигийн захирагч Аль-Нахьян овгийн тэргүүн Ерөнхийлөгчөөр, Дубайн захирагч Аль-Мактум овгийн тэргүүн Дэд ерөнхийлөгчөөр тус тус томилогддог. Эмирт (арабаар Имара) гэдэг нь Эмирийн удирдсан улс гэсэн утгатай ч АНЭУ-ын төрийн тэргүүнийг Эмир

бус Ерөнхийлөгч гэдэг. Катар Улсыг (арабаар Давлат аль-Катар) Аль-Тани, Кувейт Улсыг (арабаар Давлат Аль-Кувейт) Аль-Сабах овгийн тэргүүн буюу Эмир тус тус удирддаг. Бахрейны Хаант Улсыг (арабаар Мамлакат аль-Бахрейн) Аль-Халифа овгийн тэргүүн буюу Хаан удирддаг. Оманы Султант Улс (арабаар Султанат Оман)-ыг Аль-Бу Саиди овгийн тэргүүн буюу Султан удирддаг.

Эдгээрээс Саудын Арабын эрх баригч Аль-Сауд болон Кувейтын эрх баригч Аль-Сабах овгийнхон ураг төрлийн холбоотой. Тэдэн дээр мөн Бахрейны эрх баригч Аль-Халифа овгийнхон нэмэгдэнэ. Өөрийн хэлбэл, Неждийн Утейба аймгаас угсаа гаралтай гэдгээрээ Аль-Сауд, Аль-Сабах, Аль-Халифа нар илүү ойр дотно байж, бүс нутаг, олон улсын шинж чанартай аливаа асуудлаар нэгдсэн байр суурьтай байж чаддаг.

Аль-Сауд овгийн эрчүүд Эмир (арабаар Амир), охид Эмира хэргэмтэй байдаг. Харин Катар, Кувейтын хэмжээнд зөвхөн төрийн тэргүүнийг Эмир гэдэг. Бахрейны төрийн тэргүүнийг 1783 оноос Хаким, 1971 оноос Эмир гэдэг байсан ч 1999 онд хаан ширээнд суусан шейх Хамад бин Иса Аль-Халифа 2002 оноос Хаан болгон өөрчилсөн нь нарийн учиртай. АНЭУ-ын төрийн тэргүүнийг Ерөнхийлөгч гэдэг бөгөөд шейх Халифа бин Заид Аль-Нахьян Абу Дабигийн Эмир гэсэн давхар гуншинтай. АНЭУ, Бахрейн, Катар, Кувейтын эрх баригч овгийн эрчүүд шейх, эмэгтэйчүүд шейха хэргэмтэй байдаг. Арабын хойгийн орнуудын хувьд энэхүү хэргэм зэргийн ялгаа чухал ач холбогдолтой тул практик ажлын явцад хянуур хандах нь зүйтэй юм.

Арабын хойгийн орнууд тус бүс нутагт ноёрхлоо тогтоох гэсэн Ирак, Ираны олон жилийн оролдлогод хаалт тавихын зэрэгцээ өөр хоорондын харилцаа, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах үүднээс 1981 онд Булангийн орнуудын хамтын ажиллагааны зөвлөлийг байгуулсан. 1976 онд Кувейтын Эмир шейх Жабер Аль-Ахмед Аль-Сабах АНЭУ-д айлчлахдаа тус улсын Ерөнхийлөгч шейх Заид бин Султан Аль-Нахьяанд ийм байгууллага байгуулах тухай анхны санаачилгыг гаргасан байдаг. Зөвлөлийн гишүүн орнууд нийгэм, эдийн засаг, соёлын салбарт түлхүү хамтран ажилладаг бөгөөд анх байгуулагдах үед Саудын Араб, Оманы зүгээс цэрэг, улс төрийн салбарыг үндсэн чиглэл болгох санал тавьсан ч бусад нь дэмжээгүй.

*АРАБЫН ХОЙГИЙН ОРНУУДЫН ГАДААД БОДЛОГО,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ*

1984 онд БОХАЗ-ийн гишүүн орнууд Батлан хамгаалах нэгдсэн стратегийн тухай хэлэлцээрт гарын үсэг зурцгаасан. 2009 оны 6 дугаар сард БОХАЗ-ийн гишүүн орнуудын төрийн тэргүүд Саудын Арабын нийслэл Эр-Рияд хотноо чуулж, нэгдсэн мөнгөн дэвсгэртэд шилжих тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан ба хэтийн ирээдүйд Арабын хойгоос ам.доллар, еврог шахан гаргахаар төлөвлөж байна.

1970-аад оны төгсгөл үеэс АНУ Персийн буланг геостратегийн чухал бүс нутаг, түүнээс дэлхийн эдийн засгийн тогтвортой байдал хамаарна хэмээн тунхаглаж эхэлсэн. 1979 онд ЗХУ-ын цэрэг Афганистанд нэвтэрсний дараа АНУ-ын Ерөнхийлөгч Жимми Картер “Персийн буланд хяналтаа тогтоохыг оролдох аваас АНУ-ын ашиг сонирхолд халдсантай адилд тооцогдоно. Тиймээс бүхий л шаардлагатай арга хэмжээ, түүний дотор зэвсэгт хүчин ашиглахыг үгүйсгэхгүй” гэсэн захидал ЗХУ-ын удирдлагад явуулж байв. АНУ-ын Ерөнхийлөгч Ричард Никсон болон түүнээс хойшхи Ерөнхийлөгч нар Персийн булангийн аюулгүй байдал, тогтвортой байдлыг Вашингтоны хувьд амин чухал хэмээн тодорхойлж ирсэн бөгөөд тэртээ 1980 онд Ерөнхийлөгч Ж.Картер “Персийн булан бол АНУ-ын ашиг сонирхлын онцгой бүс” хэмээн зарласан.

АНУ-ын Төрийн департамент, Батлан хамгаалах яамнаас Ерөнхийлөгч Рональд Рейган болон Конгресст илгээсэн хамтарсан илгээлтдээ “Персийн булангаас барууны орнууд руу чиглэсэн газрын тосны урсгал дээр ЗХУ хяналтаа тогтоож буй нь ноцтой хор хохирол учруулахаар байна. Бид улс төр, эдийн засгийн гадны түрэмгийллээс өөрийгөө хамгаалахын тулд Персийн булан дахь холбоотнууддаа туслах ёстой” гэж байжээ. ЗХУ-ыг тус бүс нутагт оруулахгүйн тулд Вашингтон бүхнийг хийхэд бэлэн байсан агаад түүний байр суурийг НАТО-гийн бусад гишүүн орнууд бүрэн дэмжиж байлаа. Р.Рейганы үед Персийн буланд чиглэсэн АНУ-ын бодлого идэвхжих болж, олон тооны цэрэг, тагнуулын мэргэжилтнүүд суурин ажиллах болсон.

З.Бжезински, Б.Скоукрофт, Р.Мэрфи тэргүүтэй олон улсын харилцааны нэрт зүтгэлтнүүд бичихдээ “Персийн булан бол АНУ-ын хувьд чухал бүс юм. Персийн булангаас газрын тос экспортлох нь дэлхийн эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад шийдвэрлэх үүрэгтэй. Тус бүс нутагт өрнөж буй үйл явдлууд нь Араб, Израилийн

дайн, шашны хэт даврах үзлээс эхлээд алан хядах ажиллагаа, бүр цөмийн дайнд ч шууд нөлөө үзүүлнэ” гэжээ.

Арабын хойг дахь АНУ-ын ашиг сонирхлын эх үндэс нь түүний газрын тосны нөөцтэй шууд холбоотой. Арабын хойг дахь анхны тусгаар улс Саудын Арабын 1930-аад оны үеийн орлогын гол эх үүсвэр хаж байсан бөгөөд тухайн үед дэлхийн эдийн засгийн хямрал нүүрлэсэн нь мөргөлчдийн тоог эрс бууруулж, тус улсыг санхүүгийн хүнд байдалд оруулсан. Саудын Арабын Засгийн газар 300-400 мянга орчим фунт стерлинг зээлэх замаар анхны радиогоо байгуулах, Жидда хотын усан хангамжийг сайжруулах зэрэг бүтээн байгуулалт хийж, төр засгийн хэрэгцээнд олон тооны автомашин худалдан аваад байв. Улмаар өрөө төлж дийлэхээ больсон агаад нэмж зээл олгох улс гүрэн олдсонгүй. Энэ хүнд хэцүү үед Абдул-Азиз хааны англи зөвлөх Харри Сент-Жон Филби түүнийг ятгаж, америк саятан Чарльз Ричард Крейнтэй уулзуулан, ундны усны хайгуул хийлгэхээр тохирчээ. Усны хайгуул хийх нэрийн дор ирсэн америк геологичид 1932 онд Дахран орчимд газрын тос агуулагдаж байж болзошгүйг тогтоосон ба 1938 онд анхны газрын тос илрүүлсэн. Гэвч дэлхийн хоёрдугаар дайн эхэлсэн тул газрын тос олборлолт эрчимтэй үргэлжлээгүй.

Дайны жилүүдэд Ойрхи Дорнод, тэр дундаа Арабын хойгт чиглэсэн АНУ-ын бодлого өөрчлөгдөх болж, тус бүс нутаг дахь Их Британий байр суурийг ганхуулахыг эрмэлзэж эхлэв. Энэ нь эрчим хүчний шинэ эх үүсвэр газрын тосны ач холбогдол үлэмж нэмэгдэж, стратегийн чухал бараа болон хувирсантай холбоотой. Дэлхийн хоёрдугаар дайны өмнө Их Британий банкир Эдвард Маккей Эдгар “Ойрхи Дорнодод Их Британий байр суурь туйлын бат бэх байна. Одоогоор мэдэгдэж байгаа газрын тосны бүх орд, цаашид газрын тос илэрч болох газрууд цөм АНУ-д хамаагүй. Нэг бол Их Британий гарт, түүний захиргаа хяналтын дор, эсвэл Их Британий хөрөнгөөр санхүүжигдэж байна” гэж бичиж байв. 1943 онд Саудын Арабт үйл ажиллагаа явуулж байсан Стандарт ойл оф Калифорния компаний захирлаас АНУ-ын Дотоод хэргийн сайд Харольд Икест “Саудын Арабт Их Британий эдийн засгийн нөлөө газар авч буйд санаа зовниж байна. Ингэснээр цаашид америкчуудын үйл ажиллагаанд саад учрахаар байна. АНУ-ын Засгийн газар Саудын Арабт лэнд-лиз хэлбэрээр тусламж үзүүлэх аваас тэдний газрын тос

*АРАБЫН ХОЙГИЙН ОРНУУДЫН ГАДААД БОДЛОГО,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ*

америкчуудын хяналт дор үлдэх боломж бий” гэсэн захидал явуулжээ. Удалгүй АНУ-ын Ерөнхийлөгч Франклин Рузвельт Саудын Арабын Засгийн газарт тусламж олгох үүргийг Төрийн нарийн бичгийн даргын орлогч буюу лэнд-лиз хөтөлбөрийн удирдагч Эдвард Стеттиниуст өгснөөр дайны жилүүдэд Саудын Арабт нийт 99 сая ам.долларын тусламж олгожээ.

Үүний дараа 1945 оны 2 дугаар сард Ф.Рузвельт, Абдул-Азиз нар Суэцийн суваг орчимд АНУ-ын цэргийн хөлөг онгоцон дээр нууц уулзалт хийв. Уулзалтаар АНУ-ын хөлөг онгоцуудыг Персийн булан дахь Саудын Арабын боомтуудыг чөлөөтэй ашиглах, агаарын цэргийн бааз байгуулахыг Абдул-Азиз зөвшөөрөв. Гэхдээ Саудын Арабыг эзлэн авахгүй гэсэн баталгаа хүсчээ. Хариуд нь Герман тэргүүтэй орнуудад дайн зарлах, Аль-Хасаг Газар дундын тэнгистэй холбох трансарабын газрын тосны хоолой барих саналыг нь дэмжжээ. Энэхүү уулзалтын талаар англичууд сүүлчийн мөчид мэдсэн бөгөөд Ф.Рузвельтыг ниссэний дараа Их Британий Ерөнхий сайд Уинстон Черчилль Абдул-Азизтай уулзаж, АНУ-ын нөлөөнд автахгүй байхыг ятгасан ч үр дүнд хүрээгүй. 1945 оны 3 дугаар сард Саудын Араб Герман тэргүүтэй орнуудад дайн зарласан нь НҮБ-д элсэн ороход нь дэм болсон юм.

Арабын хойгийн газрын тосны салбар дахь анхны хөрөнгө оруулалтыг АНУ, Их Британий компаниуд хийсэн бөгөөд эхний жилүүдэд АНУ-ын Стандарт ойл оф Нью-Жерси (1972 оноос Эксон), Стандарт ойл оф Калифорния (Шеврон), Тексако, Мобил (1999 оноос Эксонд нэгдсэн), Их Британий Бритиш Петролеум, Нидерландын Ройял Датч Шелл, Францын Франс де Петрол (1985 оноос Тотал) компаниуд газрын тос олборлоход голлох үүрэгтэй оролцсон. 1970 оны байдлаар зөвхөн эдгээр компаниуд дэлхийн газрын тосны олборлолтын 78%, боловсруулалтын 60%, тээвэрлэлтийн 55%-ийг эзэмшиж байв. Саудын Арабын газрын тосноос олсон орлого 1971 онтой харьцуулахад хоёр жилийн дараа 208,5%, 1976 онд 1266,2%, 1981 онд 4015,3% буюу дээд цэгтээ хүрч өссөн байдаг. Энэ 10 жилийн хугацаанд Саудын Арабын газрын тосноос олсон орлого 41 дахин өсчээ. 1973 оны Араб, Израилийн дайны үеэр АНУ тэргүүтэй барууны орнууд Израилийг дэмжсэнд хойгийн орнууд эсэргүүцэл илэрхийлж, тэдгээрт газрын тос нийлүүлэхээ зогсоосон нь дэлхийн эдийн засагт шууд сөрөг нөлөө үзүүлсэн.

1964 онд Фейсал хаан ширээнд сууснаар Саудын Арабын гадаад, дотоод бодлогод өөрчлөлт гарч эхлэв. Чухам энэ үеэс Саудын Араб Зэвсэгт хүчнээ эрчимтэй бэхжүүлж эхэлсэн бөгөөд түүний нэр Египетийн Ерөнхийлөгч Гамал Абдел Насерын хэмжээнд сонсогдох болов. 1960-аад оны сүүлчээс Саудын Араб, өмнөд хөрш Йемений харилцаа хурцдах болж, хилийн мөргөлдөөн удаа дараа гарав. Йемен хаант засаглалыг халж, бүгд найрамдах улсыг тунхагласан нь Саудын Арабын иргэдийн сэтгэл зүйд нөлөөлж, ялангуяа армийн офицерууд талархан хүлээн авах байдалтай байсан тул өргөн баривчилгаа явуулж таслан зогсоов. 1973 оны Араб, Израилийн дайны үеэр Саудын Араб ОПЕК-ийн гишүүн арабын орнуудыг оройлон АНУ тэргүүтэй барууны орнуудад газрын тос нийлүүлэхээ зогсоосонд тэдгээрийн зүгээс хэлэлцээрийн ширээний ард суухыг санал болгов. Ингэснээр 1974 онд АНУ-тай эдийн засаг, цэргийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг үзэглэх нөхцөл бүрдэж, цаашдын стратегийн түншлэлийн эхлэл тавигдсан юм.

1963 онд Кувейтыг НҮБ-д элсэн орсны дараа Иракийн шинэ Засгийн газар тусгаар тогтнолыг нь хүлээн зөвшөөрсөн ч 10 жилийн дараа ирак цэргүүд Кувейтын хилийн харуулыг байрыг эзлэн авч, Бубиан, Варба арлуудыг шилжүүлэн өгөхийг шаардав. Эдгээр арлууд нь Иракийн хөлөг онгоцуудыг Персийн буланд нэвтрэх аюулгүй гарц болох учиртай байв. Чухам энэ үед Кувейт үндэсний армия бэхжүүлэх, цэргийн найдвартай холбоотон хайж олохын чухлыг гүнээ ойлгожээ. Гэхдээ Арабын хойгийн орнууд олон арван жилийн турш Их Британий захиргаан дор оршин тогтнож ирсэн тул өөр холбоотонтой болох нууцхан зорилго тавьж байв.

1960-70-аад онд АНУ-ын Арабын хойгт чиглэсэн бодлого улам эрчимжсэн бөгөөд 1980-аад он гэхэд тус бүс нутагт бүрэн хяналтаа тогтоож чадсан. Энэ нь Арабын хойгийн орнуудын өөрсдийн аюулгүй байдалд итгэлтэй бус байснаас зэвсэглэлээр хөөцөлдөхөд хүргэж, АНУ тэргүүтэй барууны орнуудтай хамтрахаас өөр аргагүй байдалд орсонтой холбоотой. Батлан хамгаалах хамтын хүрээнд АНУ-ын цэргийн бааз, бэлтгэлийн төв, зэвсгийн агуулах зэргийг өөрсдийн нутаг дэвсгэр дээр байршуулах болов. Үүний дүнд 1987 онд АНУ-ын Ерөнхийлөгч Р.Рейган “манай улсын засаг захиргаа БОХАЗ-ийн

*АРАБЫН ХОЙГИЙН ОРНУУДЫН ГАДААД БОДЛОГО,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ*

гишүүн орнуудыг аливаа гадны түрэмгийлэл, дотоодын төрийн эргэлтээс чанд батлан хамгаална” хэмээн албан ёсоор мэдэгдсэн билээ.

1979-1989 оны ЗХУ, Афганистаны дайн, 1980-1988 оны Ирак, Ираны дайны үед Арабын хойгийн орнууд Афганистан, Иракийн талд зогсож, олон сая ам.долларын буцалтгүй тусламж олгож байв. Тухайлбал, дайны жилүүдэд Саудын Араб Афганистаны мужахедуудад 1,5-2 тэрбум ам.доллар олгосон гэдэг. Тэд ийн тусалж байсанд АНУ-ын нөлөө бий бөгөөд АНУ мужахедуудад 1987 онд 600 сая ам.доллар, 1988 онд 700 сая ам.доллар тус тус өгчээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Картерын Үндэсний аюулгүй байдлын бодлогын зөвлөх Збигнев Бжезинский зөвлөлтийн цэрэг Афганистанд нэвтрэхээс өмнө мужахедуудыг зэвсгээр хангахыг санал болгосон агаад Афганистан дахь коммунист дэглэмийг хадгалан үлдэхийн тулд ЗХУ-ыг дайран орсон мэтээр олон нийтэд харагдуулахыг зорьж байснаа хүлээн зөвшөөрсөн билээ. Удалгүй энэхүү төлөвлөгөө биеллээ олж, ЗХУ-ын Афганистан дахь үйл ажиллагаатай холбоотойгоор Арабын хойгийн орнууд түүнээс улам бүр зайгаа авах болсон. ЗХУ 1980-аад оны эхэн үе гэхэд хойгийн орнуудаас зөвхөн Кувейттэй дипломат харилцаатай байсан бөгөөд 1985 онд Омантай, 1986 онд АНЭУ-тай, 1989 онд Катартай, 1990 онд Бахрейнтай тус тус дипломат харилцаа тогтоосон. Саудын Арабын хувьд ЗХУ-аас зай барьсаар байлаа.

1990 оны 8 дугаар сард Иракийн цэрэг Кувейтэд түрэмгийлэн довтолж, нэг өдрийн дотор эзлэн авав. Энэ нь Саудын Арабаас бусад хойгийн орнууд биеэ хамгаалах чадваргүй болохыг илтгэн харуулсан юм. Хойгийн бусад орнууд Кувейтэд туслалцаа үзүүлж чадаагүй бөгөөд тэдний бүх цэрэг, зэвсэг техник нийлээд ч Иракийг дийлэхээргүй байлаа. Иракийг цэргээ гаргахыг шаардах, албадан байгуулсан “Түр Засгийн газрыг” хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ мэдэгдэхээс өөр зүйл хийж чадсангүй. Дараагийн түрэмгийлэл Иранаас Бахрейнд чиглэж болзошгүй хэмээн таамаглацгааж байв. Түрэмгийллээс 5 сарын дараа АНУ тэргүүтэй дэлхийн олон орнуудаас бүрдсэн эвслийн цэрэг “Цөлийн шуурга” байлдааны ажиллагаа явуулсны хүчинд Кувейтыг чөлөөлсөн. Энэхүү үйл явдлын дараа хойгийн орнууд батлан хамгаалах зардлаа эрс нэмэгдүүлж, 1993 онд 24,071, 1994 онд 21,725, 1995 онд 20,159 тэрбум ам.доллар болгосон. Үүнээс хамгийн их зардлыг Саудын

Араб, Кувейт төсөвлөж байв. Түүнээс гадна хойгийн орнуудад байрлах АНУ-ын цэргийн албан хаагчдын тоог эрс нэмэгдүүлсэн. Гэхдээ 2001 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Саудын Арабын хунтайж Абдалла “арабын, эсвэл исламын аль нэг улсын эсрэг байлдааны ажиллагаа явуулах америк цэргүүдийг Саудын Арабын нутаг дэвсгэрээс ийм үйл ажиллагаа явуулахыг хүлээн зөвшөөрөхгүй” хэмээн мэдэгдсэн. Энэ нь Афганистанд явуулсан цэргийн ажиллагаатай холбоотой.

2003 оны 3 дугаар сард АНУ Иракт довтлохын өмнө Арабын хойгийн орнууд Ерөнхийлөгч Саддам Хусейны дэглэмийг унагах сонирхолтойгоо илэрхийлж байсан бөгөөд АНЭУ-ын шейх Хамид бин Султан Аль-Нахьян С.Хусейныг сайн дураараа албаа өгөхийг зөвлөснийг Бахрейны Хаан шейх Хамад бин Иса Аль-Халифа, Кувейтын Эмир шейх Жабер Аль-Ахмед Аль-Сабах, Саудын Арабын Үе залгамжлах хунтайж Абдалла бин Абдул-Азиз Аль-Сауд нар дэмжсэн мэдэгдэл хийж байв. С.Хусейны дэглэм нуран унахад эдгээр орны иргэд баяр хөөртэйгээр угтан авсан ч тус улсад үүссэн тогтворгүй байдал өнөөг хүртэл үргэлжилж, тэдгээрийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлнэ чинээ санаагүй билээ.

Арабын хойгийн орнууд гол аюул заналхийлэл Иранаас ирнэ гэж үздэг бөгөөд олон жилийн өмнөөс дайсагнасан харилцаатай явж ирсэн. Тухайлбал, Саудын Араб бүс нутаг дахь давамгайллын төлөө ширүүн өрсөлдөж, цөмийн хөтөлбөрийн эсрэг хатуу байр суурь баримталдаг бол АНЭУ газар нутгийн маргаантай, Бахрейн шийтгүүдийн асуудлаар эмзэг гэх мэтээр цааш үргэлжилнэ. Шашны урсгал хоорондын зөрчил үүнд голлох нөлөөг үзүүлдэг. Бахрейнаас бусад хойгийн орнуудын иргэдийн үнэмлэхүй олонхи нь сүннитууд бол Ираны хүн амын 90-95 хувийг шийтгүүд эзэлдэг.

5 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд АНУ, БОХАЗ-ийн гишүүн орнуудын дээд хэмжээний уулзалт болж, АНУ-ын тал Персийн буланд пуужингийн довтолгооноос хамгаалах систем байгуулахаар төлөвлөж байгаагаа мэдэгдэв. Түүнчлэн БОХАЗ-ийн гишүүн орнуудын эсрэг аливаа түрэмгийлэл, аюул заналхийллийн үед хамтран ажиллана гэдгээ нотлов. Гэвч энэхүү уулзалтад Катар, Кувейтээс бусад орны төрийн тэргүүд оролцоогүй нь тэдгээрийн хооронд үл ойлголцол бийг илтгэн харуулаад байна. Тухайлбал, АНУ-ын засаг захиргаа Ирантай цөмийн

*АРАБЫН ХОЙГИЙН ОРНУУДЫН ГАДААД БОДЛОГО,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ*

хөтөлбөрийн хүрээнд хэлэлцээ хийж буй нь арабуудад таалагдахгүй байна.

Английн Дэйли Телеграф сонин “Османы эзэнт гүрэн задран унасны дараа Арабын ертөнц хоёр үе шатыг даван туулсан. Анхлан Их Британи, Францын захиргаан дор оршин тогтнож байсан. Харин дэлхийн хоёрдугаар дайны дараа АНУ-ын нөлөөн дор шилжсэн. Өнөөдөр арабын орнууд гурав дахь үе шатандаа орох гэж байна. Энэ удаад АНУ-ыг сонгох уу” хэмээн бичсэн нь анхаарал татахаар асуудал юм.

Арабын хойгийн тэргүүлэх улс болох Саудын Арабын Хаант Улсын гадаад бодлого, аюулгүй байдлын асуудлын талаар тусад нь авч үзье.

Аль-Сауд овгийн анхны тогтоогдсон өвгийг имам Сауд ибн Мухаммад ибн Мукрин гэж үздэг бөгөөд тэрээр 1720-1725 онд Аль-Дирия хотыг захирч байсан нь тухайн үеийн гар бичмэлд тэмдэглэгдэн үлджээ. 1725 онд түүнийг нас барсны дараа хүү Мухаммад ибн Сауд хотын захирагчид өргөмжлөгдөв. Энэ үеэс түүний гэр бүл Аль-Сауд нэрийг авч, цаашид уг газар нутагт засаглах болсон. Аль-Сауд овгоос “салбарлан ургасан салаа мөчир” олон бөгөөд сүүлийн 100 гаруй жил төр барьж буй хаад өнөөгийн Саудын Арабыг үүсгэн байгуулагч буюу 1902-1953 онд хаан ширээнд суусан Абдул-Азиз ибн Абдул-Рахман Аль-Саудын хөвгүүд юм. Абдул-Азиз хааныг нас барсны дараа түүний хүү Сауд (1953-1964), Фейсал (1964-1975), Халид (1975-1982), Фахад (1982-2005), Абдалла (2005-2015) нар хаан суусан. 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдрөөс Салман хаан ширээнд суугаад байна.

Саудын Арабыг хүлээн зөвшөөрсөн анхны улсуудын нэг нь ЗХУ бөгөөд 1926 оны 2 дугаар сарын 16-ны өдөр буюу Их Британиас хоёр долоо хоногийн өмнө дипломат харилцаа тогтоосон юм. Улмаар 1932 онд залуу хунтайж Фейсал Москвад айлчилж байв. 1926 онд Нидерланд, Франц, Турктэй, 1928 онд Германтай, 1929 онд Иран, Польштой, 1931 онд АНУ-тай, 1932 онд Италитай, 1936 онд Египеттэй, 1939 онд БНХАУ-тай тус тус дипломат харилцаа тогтоосон. 1930 онд Абдул-Азиз хаан Гадаад хэргийн яам байгуулах зарлиг гаргаж, хүү Фейсалыг сайдаар томилсон байдаг. 1950 оны байдлаар Эр-Риядад зөвхөн АНУ, Их Британий ЭСЯ л үйл ажиллагаа явуулж байв.

Саудын Араб сүүлийн арав гаруй жилийн турш АНУ-ын “стратегийн түнш” гэгдэж яваа ч хоёр улсын харилцаа үргэлж дардан байгаагүй юм. 1973 оны Араб, Израилийн дайнд АНУ Израилийг дэмжсэнд эсэргүүцэл илэрхийлж, газрын тос нийлүүлэхээс татгалзаж байв. 2001 оны 9 дүгээр сарын 11-ний халдлагад оролцсон 17 хүний 15 нь Саудын Арабын иргэд байсан нь хожим ил болсон. 2003 онд АНУ Иракт түрэмгийлэн орж, С.Хусейны дэглэмийг түлхэн унагахад Саудын Араб баярлаагүй юм. Учир нь С.Хусейны үед Иракийг сүнни цөөнх удирдаж байсан бол өдгөө засгийн эрхэнд шийтүүд гараад байна. Арабын хаврын дүнд Египетийн Ерөнхийлөгчөөр Лалын ахан дүүсийн тэргүүн Мухаммад Мурси сонгогдох үеэр АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама баяр хүргэснийг Саудын Араб таатай хүлээж аваагүй бөгөөд удалгүй цэргийн эргэлт гарахад сая нэг чөлөөтэй амьсгаа авав. Египет дэх цэргийн эргэлтийг Саудын Араб, АНЭУ санхүүжүүлсэн гэж Лалын ахан дүүс баталдаг.

2013 оны 9 дүгээр сард АНУ болон Ираны Ерөнхийлөгч нар 34 жилийн дараа анх удаа утсаар ярьсан нь Саудын Арабт таалагдаагүйгээр барахгүй “Б.Обама биднийг хямдхан зарчихлаа. АНУ өөрийн түншүүдтэйгээ биеэ үнэлэгч мэт харьцаж, хэрэглээд л хаяж байна” хэмээн нутгийн сонин хэвлэлд бичиж байв. Гэхдээ бүс нутгийн томоохон “тоглогч” буюу газрын тосны хамгийн том нийлүүлэгч, сүннитүүдийн ариун газар Мекка, Медина оршдог Саудын Арабын бодлого, байр суурь өөрчлөгдөхийг АНУ хүсэхгүй нь тодорхой. Саудын Араб үл нэгдэх бодлого явуулдаг ба тэр бодлогоо АНУ-тай ойртох зорилгодоо ашигладаг.

“Хэрэв Иран цөмийн хөтөлбөрөө үргэлжлүүлэх аваас Саудын Араб цөмийн зэвсэггүй статусаасаа татгалзана. Иран цөмийн хөтөлбөр хэрэгжүүлж байхад бид яагаад болохгүй гэж. Ираныг уран баяжуулахыг зогсоож чадахгүй бол Ойрхи Дорнодод, дараа нь бүх дэлхий даяар цөмийн зэвсгээр хөөцөлдөж эхэлнэ” хэмээн мэдэгдсэн Саудын Арабын эрх баригчид өнгөрсөн 3 дугаар сард БНСУ-тай цөмийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр үзэглэсэн бөгөөд БНСУ тус улсад хоёр цөмийн реактор барьж өгөхөөр тохиролцоод байна. Үүнээс өмнө БНХАУ, Франц, Аргентинтай ийм хэлэлцээр байгуулсан юм. Саудын Араб ойрын хорин жилд нийт 16 цөмийн

*АРАБЫН ХОЙГИЙН ОРНУУДЫН ГАДААД БОДЛОГО,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ*

реактор барихаар төлөвлөснөө зарлаад байна. Нэгэн цагт Саудын Араб Пакистаны цөмийн хөтөлбөрийг санхүүжүүлж, дотно харилцаатай явж ирсний хувьд пакистанчууд тэдэнтэй цөмийн зэвсгийн нууцаасаа хуваалцахгүй гэх баталгаа үгүй.

2016 оны АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Бүгд найрамдах намаас нэр дэвшигч ялсан тохиолдолд Ираны талаар явуулж буй өнөөгийн Ерөнхийлөгчийн бодлогыг үргэлжлүүлэх нь тун чиг эргэлзээтэй хэмээн Саудын Арабын судлаачид үзэж байна. “Ерөнхийлөгч Б.Обама ажлаа өгнө, манай “өвгөчүүл” хаан ширээнээ заларсаар л байна” хэмээн Саудын Арабын тоймч бичжээ. Саудын Араб АНУ-гүйгээр бүс нутаг дахь байр сууриа энэ хэвээр хадгалахад хэцүү бол АНУ Саудын Арабын дэмжлэггүйгээр Исламын улсыг “ялахад” хэцүү.

Саудын Арабын хувьд бүс нутаг дахь өөрийн үүрэг оролцоог хэвээр хадгалахын тулд жилээс жилд хүчирхэгжиж буй хөрш Ираны нөлөөг саармагжуулах чиглэлээр боломжтой бүхнийг хийхийг эрмэлзсээр байна. Саудын Араб Ираны эсрэг эрс шийдэмгий байр суурь баримталж байснаараа нэр хүндийг олж, арабын бусад хаант улсуудаар өөрийгөө хүрээлүүлэн, лидерийн эгнээнд эргэлт буцалтгүй орж байв. Ирантай харилцаагаа сайжруулах оролдлого хийх нь түүний холбоотнуудын хувьд ялагдал, харин иранчуудын хувьд ялалт болох юм. Хэрэв ингэсэн тохиолдолд Йемен, Иракийн зүгээс ирэх аюулыг багасгах, Сирийн дайнаас хохирол багатай гарах, Дорнод муж дахь шийтүүдийн бухимдлыг намжаах эерэг талтай. Дорнод мужийн Даммам, Дахран, Хуфуф зэрэг томоохон хотын иргэдийн талаас илүү хувь нь шийтүүд агаад улсын хэмжээнд нийт 3 сая гаруй шийтүүд байна. Дорнод муж Саудын Арабын бүрэлдэхүүнд багтах болсон 1914 оноос Аль-Жилуви овгийнхон уг мужийг удирдаж ирсэн ч 1985 оноос эрх баригч Аль-Сауд овгийн эмир удирдах болсон юм. 1985 онд Фахад хаан засгийн эрхэнд гараад удаагүй байхдаа өөрийн хүү Мухаммадыг мужийн захирагчаар томилсон нь цаанаа учиртай.

Саудын Араб тэргүүтэй Арабын хойгийн орнуудын эрх баригчид гол аюул заналхийлэл Иранаас ирнэ гэж үзсээр байна. Шахын дэглэмийн үед Эр-Рияд, Тегераны харилцаа ажил хэрэгч хэв шинжтэй байсан ч Иранд исламын хувьсгал ялсны дараачаас харилцаа эрс

муудсан. Шашны урсгал хоорондын олон зуун жилийн дайсагнал дээр улс төрийн өрсөлдөөн нэрмээс болж, Ираны холбоотон Сири) Ерөнхийлөгч Башар Аль-Асад алави буюу шийт(-ийг үгүй хийхийн тулд Сирийн босогчдыг илтэд дэмжиж, зэвсэг техник нийлүүлэхийн зэрэгцээ босогчдыг цэргийн эрдэмд сургаж байна. Башар Аль-Асадын дэглэмийг түлхэн унагах гэж яваад шинэ бөгөөд илүү аюултай нүүр тулсан нь Исламын улс бүлэглэл юм. Исламын улсын толгойлогчдын зүгээс Аль-Саудын үр удам ялзралд автсан, исламын ертөнцийн ариун газар Медина, Мекка жинхэнэ сүсэгтнүүдийн гарт буюу Исламын улсын мэдэлд ирэх ёстой хэмээн тунхаглах болов. “Одоогийн байдлаар Исламын улсын мэдэлд Иракийн газар нутгийн гуравны нэг, Сирийн газар нутгийн дөрөвний нэг байгаа бөгөөд цаашид эдгээр газар нутгийг нэгтгэх замаар дараагийн бай буюу Саудын Араб, Йорданд нэвтэрнэ. Чингэснээр Исламын улс эдийн засгийн хүчирхэг бааз суурьтай болж, цаашлаад Арабын хойгийн жижиг хаант улсуудыг ч эрхэндээ оруулна” хэмээн ОХУ-ын нэрт араб судлаач Г.И.Мирский үзэж байна. ОХУ-ын зүгээс Исламын улсыг НҮБ-ын Аюулгүй зөвлөлөөс гаргадаг террорист байгууллагуудын жагсаалтад оруулахыг санал болгоход, АНУ эсрэг санал өгсөн, америкчууд Исламын улсыг Аль-Каида (бааз гэсэн утгатай араб үг)-гийн салбар гэж үздэг хэмээн ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавров баталж байна.

Улс орны гадаад орчин эгзэгтэй үед Абдалла хаан нас барж, шинээр хаан ширээнд суусан Салман Засгийн газрын бүрэлдэхүүнд томоохон өөрчлөлт хийсэн нь дотоодод үл ойлголцол үүсгэв. Нас өндөр болсон хунтайж нар бие барсан тохиолдол гарсантай холбогдуулан үе залгамжлагч хунтайжийн орлогчийг томилдог болсон нь урьд хожид байгаагүй үзэгдэл болов. Үе залгамжлах хунтайж Мукрины орлогчоор түүний ах хунтайж Наиф агсны хүү Дотоод хэргийн сайд Мухаммад томилогдсон. Гэвч гурван сарын дараа Салман хаан Мукриныг хунтайжаас чөлөөлөв. Мухаммад бин Наифийг хунтайжид өргөмжилж, өөрийн хүү Мухаммадыг орлогч хунтайжаар томилов. Абдул-Азиз хааны ач нараас Үе залгамжлах хунтайж тодорч эхэлж буй нь энэ юм. Хунтайж Мухаммадын дээр олон үеэл ах нар бий атал чухам тэрээр ийн сонгогдсонд дургүйцсэн эмирүүд цөөнгүй байна. Тус улсын түүхэнд хааныг ордны эргэлтээр авч хаясан, тэр байтугай

*АРАБЫН ХОЙГИЙН ОРНУУДЫН ГАДААД БОДЛОГО,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ*

амь насыг нь бүрэлгэсэн “хар хуудсууд” бий.

Үе залгамжлагч хунтайж бөгөөд Сайд нарын зөвлөлийн орлогч, Дотоод хэргийн сайд Мухаммад бин Наиф “Сирийн дайнд оролцсон сауд иргэд эх орондоо эргэж ирснээр улс орны аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй” гэсэн нь үнэн үг юм. Өмнө нь Зөвлөлт-Афганы дайны үед шурави (персээр Зөвлөлтийн цэргүүдийг ийн нэрлэдэг байв)-гийн эсрэг тулалдаж асан сауд цэргүүд нутаг орондоо буцаж ирээд асуудал үүсгэж байв. Саудын Арабын сүннит иргэдийн дунд явуулсан судалгаанд оролцогсдын 51 хувь нь Хамасын үйл ажиллагааг, 31 хувь нь Лалын ахан дүүсийн үйл ажиллагааг дэмждэгээ илэрхийлжээ. Тэр байтугай 13 хувь нь шийтийн Хизбаллагийн үйл ажиллагааг талархан дэмждэгээ илэрхийлжээ. Харин 5 хувь нь Исламын улсыг дэмждэгээ мэдэгдсэн бол 92 хувь нь Исламын улсын үйл ажиллагааг мусульманчуудын үнэт зүйлсийг хамгаалж буй хэмээн үзжээ. Саудын Арабын иргэд Исламын улсын арга ажиллагааг буруушаадаг ч чухам тэд л биднийг шийт, еврей, америкчуудаас хамгаалж байна хэмээн үзжээ. Гэхдээ Исламын улсын дайчид Йорданы нисгэгч Муаз Аль-Касасибаг амьдаар нь шатаасан үйлдэл нь дээрх бодлыг тээгчдийг зохих хувиар цөөлсөн гэдэгт найдна.

Саудын Араб ЗХУ-тай 1926 онд дипломат харилцаа тогтоосон ч 1930-аад оны сүүлчээр Жидда дахь ЗХУ-ын консулын газрын бие бүрэлдэхүүн хэлмэгдүүлэлтэд өртөн дипломат төлөөлөгчийн газар хаагдсанаар харилцаа тасраад байв. АНУ-тай ойр дотно болсон нь мэдээж дараагийн жилүүдэд шууд нөлөөлсөн. 1990 онд Ирак Кувейтэд довтлох үеэр ЗХУ Иракийг цэргийг гаргуулахаар чармайж эхлэхэд Саудын Арабын байр суурь өөрчлөгдөж, дипломат харилцаагаа сэргээсэн юм.

Саудын Араб газрын тос олборлолтын хэмжээгээр дэлхийд тэргүүлж, зарим үед ОХУ-д тэргүүлээ алддаг (жил бүр харилцан адилгүй хэмжээгээр олборлодог) ба чухам үүнтэй холбоотой асуудлаар нууц хэлэлцээр хийж байгаа гэх мэдээлэл цацагдаад удаагүй байна. Саудын Арабын зүгээс ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путиныг Сирийн Ерөнхийлөгч Башар Аль-Асадыг дэмжихээ зогсоовол газрын тосны олборлолтоо багасгаж, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийг нэмэгдүүлэх замаар ОХУ-ын эдийн засагт эерэг нөлөө үзүүлье

гэжээ. Гэвч ОХУ-ын Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч болон ГХЯ-наас уг мэдээллийг няцаасан. АНУ-ын нэрт эдийн засагч Фредерик Энгдаль “АНУ-ын засаг захиргаа ОХУ-д хохирол учруулахын тулд Саудын Арабтай хуйвалдан газрын тосны үнийг унагасан” гэж бичсэн нь анхаарал татна.

2013 оны 8 дугаар сард Саудын Арабын Тагнуулын газрын дарга Бандар бин Султан Аль-Сауд Москвад очиж Ерөнхийлөгч В.Путинтай уулзах үеэрээ, ОХУ Сирийн Ерөнхийлөгч Башар Аль-Асадыг дэмжихээ зогсоовол бид Сочигийн өвлийн Олимпийн наадмын аюулгүй байдлыг хангахад оролцоё, Чечений террористуудын үйл ажиллагаанд нөлөөлж чадна хэмээн мэдэгдсэн гэдэг. 1990-ээд оноос Саудын Араб тэргүүтэй хойгийн орнууд ОХУ дахь ислам шашны нийгэм, улс төрийн нөлөөг идэвхжүүлэхийг зорих болсон юм. Саудын Арабын дэмжлэгтэйгээр Бүх дэлхийн Исламын холбоо, Бүх дэлхийн Ислам залуучуудын холбоо, Бүх дэлхийн Исламын сүмүүдийн хэрэг эрхлэх дээд зөвлөл зэрэг панисламист байгууллагууд Хойд Кавказ, тэр дундаа Чечений салан тусгаарлагчдад санхүүгийн үлэмж тусламж үзүүлсэн. Саудын Арабын эрх баригчид анхандаа Чечень, Дагестаны асуудлыг ОХУ-ын дотоод хэрэг хэмээн албан ёсоор мэдэгдэхийн хажуугаар дайнаас дүрвэгсдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэхийг санал болгож байв. Улмаар Чечений дүрвэгсдэд зориулан хандив цуглуулах аян өрнүүлсэн нь ОХУ-ын эсрэг үзэлтнүүдийг нийгмийн дунд бий болгосон. Энэ үед Саудын Арабын хэвлэлүүд Оросын армийн үйлдлийг буруушаан, чеченүүдэд материаллаг тусламж үзүүлэх, тэдний төлөө залбирахыг уриалж, ингэх нь жихадад оролцож буй хэлбэр хэмээн бичиж байв. 1999 оны 12 дугаар сард холбооны цэргүүд Грозный хотыг бүслэн авсны дараа Саудын Арабын Засгийн газар уг үйлдлийг эрс буруушааж байгаагаа мэдэгдсэн юм. Үүнтэй холбогдуулан Чечений дүрвэгсдэд зориулан 12 сая ам.доллар цуглуулсны 5 саяыг Фахад хаан хандивласан гэдэг. Энэ нь Саудын Арабын нэр хүндийг исламын орнуудын дунд эрс өсгөсөн явдал болсон.

ОХУ-ын Ойрхи Дорнодын хүрээлэнгийн захирал Е.Я.Сатановский “2002 оны 10 дугаар сард Москва хотын Мельниковын гудамжин дахь Соёлын төвд (Норд Ост) болсон террорист халдлагыг Саудын Арабын эмир Турки бин Фейсал Аль-Сауд зохион байгуулсан. Энэ хүн Аль-

*АРАБЫН ХОЙГИЙН ОРНУУДЫН ГАДААД БОДЛОГО,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ*

Каидаг үүсгэн байгуулж, үйл ажиллагааг нь зохицуулдаг. Халдлага болох үед тэрээр Москвад ирсэн байсан. Саудын Араб Чеченд салафи үзлийг түгээхийн зэрэгцээ цаашид тусгаар улс болгохоор төлөвлөж байсан” гэж батлаад “В.Путин Ж.Бушт Иракийг бөмбөгдөх яах вэ, Саудын Арабт анхаарлаа хандуулаач ээ гэж хэлж байсныг санацгаая” гэсэн байдаг.

2008 онд ОХУ-ын Российские железные дороги (РЖД) компани Саудын Арабын Аль-Забира хотоос Халидын нэрэмжит олон улсын нисэх онгоцны буудал хүртэл төмөр зам барих тендерт ялсан боловч Саудын Арабын тал тендерийг хүчингүй болгосон. РЖД компаний ерөнхийлөгч В.Якунин энэ талаар “уг шийдвэр манай компаний үйл ажиллагаа, хүчин чадалтай холбоогүй, олон улсын харилцааны асуудал” хэмээн мэдэгдсэн. Арабын хойгийн орнуудад АНУ-ын нөлөө үлэмж их тул ОХУ-тай харилцах асуудлаар америкчуудтай урьдчилан зөвшилцөх нь олонтаа.

Бүс нутгийн хэмжээнд Саудын Арабын байр суурьт нөлөөлөх хүчин зүйлс гарч ирсээр байгаагийн нэг нь Турк, Лалын ахан дүүсийн дэмжлэгтэйгээр 2010-2013 онд “арабын хавар”-ын давалгааг өөрт ашигтайгаар эргүүлж чадсан, хэний ч төсөөлөөгүй Катар юм. Катарын удаа дараагийн улс төрийн үйлдэлд дургүйцсэн Саудын Араб, АНЭУ, Бахрейны зүгээс сануулга болгож, өнгөрсөн оны 3 дугаар сарын 5-ны өдөр Дохад суугаа элчин сайд нараа дуудаж байв. Үүнээс хоёр хоногийн дараа Саудын Араб Лалын ахан дүүсийг террорист байгууллага хэмээн зарлахын хамт жижиг газар нутаг, цөөн хүн амтай улс “хаана байх ёстойг” Катарт сануулаад авсан. Үүнээс өмнө 2012 оны 5 дугаар сард Бахрейн, Саудын Арабын холбооны улс байгуулах тухай асуудал БОХАЗ-өөр хэлэлцэгдэж байв. Хэрэв чингэсэн тохиолдолд Катарын Эмир, Оманы Султаны төлөөлөгч нар БОХАЗ-өөс гарна хэмээн сүрдүүлсэн гэж Ираны хэвлэлүүд бичсэн. Энэхүү асуудлыг Ираны парламентын спикер Али Ларижани эрс буруушаахад парламентын 190 гишүүн түүнтэй санал нэг байгаагаа илэрхийлсэн. Парламентын гишүүдийн зүгээс “түүхэн үнэн ирж, Бахрейн Ираны 27 дахь муж болно” хэмээн мэдэгдэл хийж байв.

Саудын Араб үргэлж байлдааны бэлэн байдалд байж, зэвсэглэлээ сайжруулахыг зорьж байгаа ба 2013 онд 360 сая еврогийн өртөг бүхий зэвсэг, техник Германаас худалдан авахаар тохирч байв. Түүнээс гадна 2.5 тэрбум еврогийн өртөг бүхий таван ширхэг усанд шумбагч онгоц тус улсаас худалдан авахаар болсон тухай мэдээлэл байна. Гэвч өнгөрсөн 2 дугаар сард Германы цэргийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниудад Саудын Арабаас энэ төрлийн захиалга авахгүй байхыг Засгийн газраас нь үүрэгджээ. Энэхүү шийдвэрийг гаргасан хуралдаанд канцлер Ангела Меркель, түүний танхимын найман гишүүн оролцжээ. Чингэхдээ Ойрхи Дорнодын бүс нутагт нөхцөл байдал тогтворгүй байгаа өнөө үед герман зэвсэг, техник террористуудын гарт орж болзошгүй хэмээн болгоомжилсон аж.

Саудын Арабын Засгийн газар зарим тохиолдолд эрс шийдэмгий шийдвэр гаргах нь цөөнгүй. Энэ нь магадгүй араб хүний сэтгэлийн хөөрөлтэй холбоотой байж болох талтай. Тухайлбал, өнгөрсөн 2 дугаар сард Шведийн Гадаад хэргийн сайд Маргот Вальстрем парламентын хуралдаан дээр илтгэл тавихдаа “Саудын Арабын Засгийн газар эмэгтэйчүүдийн эрхийг зөрчсөөр байна, блогч Раиф Бадавиг хууль бусаар яллаж шийтгэсэн, дарангуйллын дэглэм ноёрхсон орон” хэмээсэнд Саудын Араб эсэргүүцэл илэрхийлж, 3 дугаар сарын 9-ний өдөр Каир хотноо болсон АОХ-ны Гадаад хэргийн сайд нарын уулзалтын үеэр М.Вальстрем үг хэлэх байсныг цуцлуулсан билээ. Үүний хариу болгож дараагийн өдөр нь Шведийн зүгээс Саудын Арабтай батлан хамгаалахын салбарт хамтран ажиллах тухай хоёр талын хэлэлцээрийг сунгахаас татгалзсанд Саудын Араб Стокгольмоос элчин сайдаа дуудсан. АНЭУ Саудын Арабтай санал нэгтэй байгаагаа илэрхийлж, дараагийн долоо хоногт нь мөн элчин сайдаа дуудсан. Үүнээс өмнө Сирийн хэрэг явдалтай холбоотойгоор Саудын Араб Дамаскаас элчин сайдаа дуудахад Кувейт мөн адил шийдвэр гаргаж байв.

2015 оны 3 дугаар сарын 26-наас 4 дүгээр сарын 22-ны хооронд Саудын Араб тэргүүтэй арабын орнуудын эвслийн цэрэг Йеменд засгийн эрхийг булаан авсан хуситуудын эсрэг байлдааны ажиллагааг явуулав. Уг ажиллагааны гол зорилго нь Саудын Арабын хил болон Йемений хууль ёсны Засгийн газрыг хамгаалахад оршиж байгаагаас

*АРАБЫН ХОЙГИЙН ОРНУУДЫН ГАДААД БОДЛОГО,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ*

гадна газрын тос дамжин өнгөрдөг гол гарц Баб аль-Мандабын хоолойг хуситуудын гарт алдахгүйд байв. АНУ, Их Британи, Франц тэргүүтэй барууны орнууд арабын эвслийн үйл ажиллагааг дэмжсэн мэдэгдэл хийсэн. ОХУ талуудыг цэргийн ажиллагаагаа зогсоохыг уриалсан бол БНХАУ талуудыг хэлэлцээрийн ширээний ард суухыг уриалсан. Харин Ирак, Иран, Сирийн Засгийн газар цэргийн ажиллагааг эрс буруушаасан юм. Өнгөрсөн 1 дүгээр сарын 22-ны өдөр хуситууд нийслэл Сана хотыг эзлэн авснаар Ерөнхийлөгч Абд-Раббах Мансур зугтахаас аргагүй болж, төрөлх Аден хотноо очоод байв. Гэвч хуситууд Аденд цөмрөн орсон бөгөөд Ерөнхийлөгч Абд-Раббах Мансур дахин зугтсан. Саудын Араб хуситуудын Ансар Аль-Алла бүлэглэлийг террорист байгууллага хэмээн тооцдог ба 2009 онд тэдгээрийн эсрэг цэргийн ажиллагаа явуулж байсан туршлагатай.

АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Жон Керри мэдэгдэл хийхдээ, Ираны Засгийн газар хуситуудад дэмжлэг үзүүлж буй талаар нотлох баримттай гэдгээ дурдаад, бүс нутагт нөхцөл байдал тогтворгүйтэж эхэлвэл шийдмэг арга хэмжээ авна гэж байв. Түүнчлэн Ираны аюул заналхийллийг мэдэрч байгаа бүс нутгийн орнуудад дэмжлэг үзүүлнэ гэдгээ мэдэгдсэн. Ираний оюун санааны дээд удирдагч аятолла Хаменеи “эвслийн цэрэг Йемений ард түмний эсрэг геноцид үйлдэж байна. Энэ нь бүс нутагт аюултай жишиг тогтоох болно” хэмээн мэдэгдсэн. Харин Ерөнхийлөгч Хасан Рухани “Саудууд шийтүүдтэй тэмцэхийг зорьж байна. Ливан, Сири, Иракт ийм зүйл хийгээд алдаа гаргаснаа ухаарсан баймаар. Йеменд та нарыг мөн адил хувь заяа хүлээж байгаа” гэв.

Арабын хойг дахь Аль-Каидагийн салбар хуситуудын удирдагч болон Йемений Ерөнхийлөгч асан Али Абдалла Салихын толгойг авчирсан хүнд 20 кг алт өгөхөө амласан ба шийтүүдийн эсрэг тэмцэл эхлүүлэх магадлалтай гэгдэж байгаа тул хоорондоо холбоо тогтоохыг үгүйсгэх аргагүй. 2012 оноос Арабын хойг дахь Аль-Каида бүлэглэлд барьцаалагдсан Саудын Арабын дэд консул Абдалла Аль-Халди гурван жил хоригдсоны эцэст энэ хавар эх орондоо буцаад байна. Түүний оронд Аль-Каида өөрийн эмэгтэй гишүүдийг суллахыг шаардаж байсан юм.

Манай улс Саудын Арабын Хаант Улстай 2007 оны 2 дугаар сарын 12-ны өдөр дипломат харилцаа тогтоосон бөгөөд 2010 онд Саудын Арабын Газрын тос, эрдэс баялгийн сайд Али бин Ибрахим Аль-Наими айлчилснаас хойш харилцан айлчлал хийгдээгүй байж байгаад Монгол Улсын Гадаад харилцааны сайд Л.Болд 2014 оны 4 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд Саудын Арабт албан ёсны айлчлал хийсэн. Хоёр улсын түүхэнд анх удаа тохиосон энэхүү уулзалтаар сайд нар бүс нутгийн болон хоёр талын харилцааны асуудлуудаар ярилцсаны дотор бизнес, харилцан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны комисс байгуулах, Монгол Улсын нутагт мах боловсруулах хамтарсан үйлдвэр байгуулж, арабын ертөнцөд экспортлох болон манай улсад тус улсаас газрын тос нийлүүлэх боломж зэргийг хэлэлцэж, зарим ажлыг зохион байгуулахаар тохиролцсон. Айлчлалын үеэр Саудын Арабын Гадаад хэргийн сайд эмир Сауд бин Фейсал Аль-Сауд ойрын хугацаанд Улаанбаатар хотод Элчин сайдын яамаа нээнэ гэдгээ мэдэгдсэн.

ДУГНЭЛТ

Арабын хойгийн орнууд олон зуун жилийн турш их гүрнүүдийн захиргаан дор оршиж, хавсарга улс шинжтэй явж ирснээрээ тусгаар тогтнолын үнэ цэнийг гүнээ ойлгосон байдаг. Их Британий захиргаан дор олон жилийг өнгөрөөсөн ч чухам англичуудын ачаар эрх баригч овгийнхон эрх мэдлээ хадгалж, гадаад, дотоодын аюул заналхийллээс найдвартай хамгаалагдаж байсныг тэмдэглэх нь зүйтэй. 1960-аад оноос дэлхий дахинаа колониализмын систем задран унаж, хойгийн орнууд тусгаар тогтнолоо зарлаж эхэлсэн. Гэвч хөрш зэргэлдээх хүчирхэг орнуудын зүгээс аюул заналхийлэл, дарамт шахалт үзэгдсээр байсан тул өөрийгөө хамгаалах арга зам хайхад хүрсэн. Харин АНУ-ын хувьд эдгээр орнуудын газрын тосны арвин нөөц чухал хэрэгцээтэй байснаараа харилцан ойлголцох нь хялбар байлаа. Тиймээс Персийн булан бол АНУ-ын ашиг сонирхлын онцгой бүс хэмээн зүгээр ч нэг зарлаагүй нь харагдана.

Арабын хойгийн орнууд улс үндэстэн, цаашлаад бүс нутгийн аюулгүй байдлыг хангах баталгаа болгож, их гүрнүүдтэй батлан

*АРАБЫН ХОЙГИЙН ОРНУУДЫН ГАДААД БОДЛОГО,
АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ*

хамгаалах салбар дахь хамтын ажиллагааг хөгжүүлэхийг чармайсан нь үр дүнтэй алхам болсон. Тухайлбал, АНЭУ Францтай батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулж, АНЭУ гадны түрэмгийлэлд өртсөн тохиолдолд Франц 75 мянган цэргийн албан хаагчийг тус улсын нутаг дэвсгэр дээр нэн даруй буулгах үүрэг хүлээж байна. Ийм агуулгатай гэрээ хэлэлцээр байгуулахын зэрэгцээ их гүрнүүдийг цэргийн бааз байгуулахыг зөвшөөрч, байнгын цэрэг байршуулж буй нь аюулгүй байдлын томоохон баталгаа болж байна. Арабын хойгийн орнууд дэлхийн газрын тосны нөөцийн 36%, байгалийн хийн нөөцийн 22%-ийг дангаар эзэмшдэг нь дараагийн зуун гартал элбэг ашиглах нөөц юм. Тиймээс их гүрнүүдийн ашиг сонирхол тус бүс нутагт төдий хугацаанд оршоор байхаар байна.

Улс орны аюулгүй байдлыг хангах асуудал гадаад бодлогын хэрэгжилттэй харилцан шүтэлцээтэй тул Арабын хойгийн орнууд чиг баримжааны хувьд АНУ тэргүүтэй барууны орнуудын талыг баримталдаг бөгөөд энэ нь ОХУ, Иран, Сири зэрэг орнуудтай харилцах харилцаанд шууд илэрч байна. Олон арван жилийн турш аюул заналхийлэл дагуулж ирсэн хөрш Ирак дахин чингэх чадамжгүй болсон ч Ираны бүс нутаг дахь жанжлах бодлого, цөмийн хөтөлбөрийн хэрэгжилт, шийтгүүдэд үзүүлж буй дэмжлэг хэвээр үргэлжилж буй нь хойгийн орнуудын санааг зовоосоор байна. Түүнчлэн Йемений засгийн эрх хуситууд (шийтгүүд)-ийн гарт байх аваас Адены хоолой хяналтаас гарч, газрын тосны тээвэрлэлтэд хүндрэл үүсэх магадлалтай тул барууны орнууд ийм байдал үүсэхээс сэргийлж, хойгийн орнуудад бүх төрлийн дэмжлэг үзүүлэх төлөвтэй байна.

Манай улс Арабын хойгийн орнуудаас анх 1975 онд Кувейт Улстай дипломат харилцаа тогтоосон бөгөөд хойгийн бусад орнуудтай 1992-2007 оны хооронд дипломат харилцаа тогтоосон юм. Арабын хойгийн орнууд нүүдэлчин соёл иргэншилтэй, хүн ам цөөн, байгалийн асар их баялагтай гэдгээрээ манай улстай адил төстэй. Зан байдлын хувьд ч нийтлэг чанарууд олон бий. 1930-аад оноос тус бүс нутагт газрын тосны арвин нөөц илэрч, санхүүгийн гачигдлын улмаас барууны орнуудаас хөрөнгө оруулалт татахаас аргагүйд хүрч, улмаар барууны компаниуд орж ирэн үйл ажиллагаа явуулахдаа ашиг орлогын дийлэнх хувийг халаасалдаг байснаас ард түмний уур бухимдал

дээд цэгтээ хүрч байсан саяхны түүх бий. Гэхдээ хойгийн арабууд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, түүнээс олсон орлогоо ард түмэндээ тэгш хүртээх аргачлалыг гаргууд боловсруулж, дэлхий нийтийн анхаарал татахуйц үр дүнд хүрч чадсан тул тэднээс суралцах шаардлагатай байна. Түүнээс гадна иргэдийн ахуй амьдрал сайжрахын хэрээр хүн ам цөөтэй орнууд ажиллах хүчний хомсдолд орж, гадаадаас олноор нь авчрахад хүрдэгтэй холбогдуулан гадаадын иргэдийн эрх зүйн байдлыг хэрхэн боловсронгуй болгох тухайд туршлага судлах боломжтой.

НОМ ЗҮЙ

1. Britannica ширээний нэвтэрхий толь. УБ, 2011
2. Александров И.А. Монархии Персидского залива: этап модернизации. Москва, 2000 г.
3. Вавилов А.И. Политика США в мусульманском мире на примере арабских стран. Опыт критического анализа. Москва, 2009 г.
4. Васильев А.М. История Саудовской Аравии. Москва, 1999 г.
5. Косач Г.Г., Мелкумян Е.С. Внешняя политика Саудовской Аравии. Москва, 2003 г.
6. Олимпиев А.Ю., Хазанов А.М. Международные проблемы Ближнего Востока 1960-е – 2013. Москва, 2015 г.
7. Cooper, Andrew Scott. The Oil Kings: How the U.S., Iran and Saudi Arabia Changed the Balance of Power in the Middle East. US, 2012
8. Davidson, Christopher. Power and Politics in the Persian Gulf Monarchies. UK, 2011
9. Gause, F.Gregory. The International Relations of the Persian Gulf. UK, 2009
10. House, Karen Elliot. On Saudi Arabia: It's People, Past, Religion, Fault Lines-and Future. US, 2013